



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 01 сарын 14 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот


Дэд хорооны даргыг сонгох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.10, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсэг, Байнгын хорооны санал хураалтын дүнг үндэслэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Тусгай хяналтын дэд хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Гаваагийн Батхүүг улируулан сонгосугай.

2.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Ж.ЭНХБАЯР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 01 сарын 14 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Чиглэл өгөх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлалын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, санал дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын хэсгийн танилцуулга, санал, дүгнэлтийг үндэслэн дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /М.Сайханбилэгт/-т чиглэл болгосугай:

1/Гадаад бодлогын стратегийн зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор “Гадаад бодлогын үзэл баримтлалыг хэрэгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр”-ийг үндэслэл, шаардлагыг тодорхой тусган боловсруулж батлан, уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөрөнгийг улсын төсөвт жил бүр тусгаж байх;

2/Байнгын хорооны 2014 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 06 тоот тогтоолын хэрэгжилтийг хангах, Төрийн гадаад харилцааны тухай хуулийн төслийг шинээр, мөн Дипломат албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд даруй өргөн мэдүүлэх;

3/Хоёр хөрштэй харилцах харилцааны түвшинг бататган, дээд, өндөр түвшний айлчлалуудын үеэр хэлэлцэн тохиролцсон гэрээ, хэлэлцээрүүдийг хэрэгжүүлэх, эдийн засгийн гадаад харилцаанд тэнцвэртэй бодлого баримтлах, ОХУ-тай хөрөнгө оруулалт, гадаад худалдааны салбарт бодит дэвшил гаргах;

4/“Гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд харилцаа, хамтын ажиллагаагаа илүү бодит үр дүнтэй болгох зорилгоор тухайн улс орнуудтай хамтран тодорхой хугацаанд хамтран хэрэгжүүлэх зорилтуудын нарийвчилсан хөтөлбөр гаргаж, биелэлтийг хангах, үйл ажиллагааг нь идэвхжүүлэх;

5/Монгол Улс дэлхийн хамтын нийгэмлэгийн гишүүний хувьд бүс нутгийн болон дэлхийн чанартай тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд санаачилгатай ажиллах, бүх нийтийн үйл хэрэгт хувь нэмэр оруулах, энхийг сахиулах, ардчиллыг бэхжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хангахад чиглэсэн үйл ажиллагааг дэмжих “Олон улсын хамтын ажиллагааны сан”-гийн хөрөнгийн тодорхой хувийг улсын төсвөөс гаргаж түүнтэй тэнцэхүйц хэмжээний хөрөнгийг зохих олон улсын байгууллага, гадаад улс орнуудын Засгийн газраас санхүүжүүлэх зарчмыг баримтлан сангийн үйл ажиллагааг идэвхжүүлэх;

6/Монгол Улсын гадаад харилцаа нь эдийн засгийн өгөөжийг тооцсон, бодитой байх зарчимд үндэслэсэн байх, Монгол Улсын эдийн засгийн чадавхийг

бэхжүүлэх зорилгоор “Монгол Улсын эдийн засгийн гадаад харилцааны хөтөлбөр”-ийг боловсруулж, батлуулах;


7/Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, энэ талаарх эрх зүйн зохицуулалтыг бий болгож, үйл ажиллагааг идэвхжүүлэх;

8/“Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан”-гийн үйл ажиллагааг иргэдэд илүү хүртээмжтэй болгох, үүнд зориулах хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж, жил бүрийн төсөвт тусгах;

9/Монгол Улсын түүх, соёлын уламжлал, эдийн засаг, нийгмийн салбарын ололтыг гадаадад сурталчилах ажлыг идэвхжүүлэх, энэ үүднээс “Монгол Улсыг гадаадад сурталчилах хөтөлбөр”-ийг боловсруулж батлан, шаардагдах хөрөнгө, санхүүгийн асуудлыг шийдвэрлэж байх;

Хоёр. Энэ тогтоолын хэрэгжилтийн явцын талаарх мэдээллийг 2015 оны эхний хагас жилд багтаан Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд ирүүлэх, биелэлтийг 2015 оны дөрөвдүгээр улиралд багтаан тус Байнгын хорооны хуралдаанд танилцуулахыг Гадаад хэргийн сайд /Л.Пүрэвсүрэн /-д даалгасугай.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Ж.ЭНХБАЯР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 02 сарын 04 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.8 дахь заалт, 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.11 дэх хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлын Аюулгүй байдал гадаад бодлогын байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Монгол Улсын "Төрийн цэргийн бодлогын үндэс" баримт бичиг болон "Зэвсэгт хүчний байгуулалтыг 2015 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр"-ийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, цэргийн зэвсэглэл, техникийн хадгалалт, хамгаалалтын байдалд шалгалт хийж санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

Ажлын хэсгийн ахлагч:

Н.Энхболд -Улсын Их Хурлын гишүүн

Гишүүд:

Г.Батхүү -Улсын Их Хурлын гишүүн
М.Батчимэг -Улсын Их Хурлын гишүүн
Л.Болд -Улсын Их Хурлын гишүүн
О.Содбилэг -Улсын Их Хурлын гишүүн
Ц.Оюунбаатар -Улсын Их Хурлын гишүүн

2. Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, шийдвэрийн төсөл боловсруулах, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын дэд хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

Дэд ажлын хэсгийн ахлагч:

Ч.Сосорбарам -Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ахлах зөвлөх

Гишүүд:

Г.Сайханбаяр -Батлан хамгаалах яамны Стратеги бодлого, төлөвлөлтийн газрын дарга

Э.Бямбажав -Батлан хамгаалах яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга

Ж.Бадамбазар -Зэвсэгт хүчний жанжин штабын Бодлого, стратеги төлөвлөлтийн газрын дарга

Д.Мягмар

Геополитикийн хүрээлэнгийн захирал

Ш.Хишигсүрэн


Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын
байнгын хорооны зөвлөх

С.Эрдэнэчимэг

Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын
байнгын хорооны референт

3.Ажлын хэсгийн санал, дүгнэлт болон шийдвэрийн төслийг 2015 оны 10 дугаар сард багтаан Байнгын хорооны хуралдаанд танилцуулахыг ажлын хэсэг, дэд ажлын хэсгийн ахлагч нарт даалгасугай.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Ж.ЭНХБАЯР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 02 сарын 16 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 5 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Монгол Улсын Засгийн газар, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага хооронд байгуулах “Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төслийн нэмэлт зээлийн хэлэлцээр”-ийг зөвшилцөхөөс өмнө төслийн хэрэгжилтэд аудитын дүгнэлт гаргуулах, төслийн үйл ажиллагаатай танилцах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Болор Улсын Их Хурлын гишүүн

Гишүүд:

Л.Эрдэнэчимэг Улсын Их Хурлын гишүүн
Н.Номтойбаяр Улсын Их Хурлын гишүүн


Хоёр. Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх дэд хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллуулсугай:

Ч.Сосорбарам	Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны Ажлын албаны ахлах зөвлөх
С.Төмөрхүү	Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор
Б.Анхбаатар	Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын шинжээч
З.Мөнх-Оргил	Сангийн яамны Санхүүгийн төрийн захиргааны удирдлагын газрын Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга
Ё.Амарбат	Сангийн яамны Санхүүгийн бодлого, өрийн удирдлагын газрын Өрийн удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн
Д.Түвшинбилэг	Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны Ажлын албаны референт
Ц.Батбаатар	Төсвийн байнгын хорооны Ажлын албаны референт

Гурав.Ажлын хэсгийн ажиллах удирдамжийг хавсралтаар баталсугай.

Дөрөв.Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг 2015 оны 02 дугаар сарын 27-ны өдөр Байнгын хорооны хуралдаанд танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч /Б.Болор/-т даалгасугай.


АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Ж.ЭНХБАЯР

2015 оны ⁰² дугаар
сарын 16-ны өдөр

БАТЛАВ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА



Ж.ЭНХБАЯР

Улаанбаатар
хот

АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

Ажлын хэсгийн зорилго:

“Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төсөл”-ийн хэрэгжилтэд аудитын дүгнэлт гаргуулах, төслийн үйл ажиллагаатай танилцах.


Ажлын хэсгийн ажиллах чиглэл:

1. “Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төсөл”-ийн хэрэгжилт, нэмэлт зээлийн тооцоолол үндэслэлтэй эсэх, төслийг бүрэн дуусгахад хангалттай эсэхэд аудитын дүгнэлт гаргуулах;

2. “Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төсөл”-ийн үйл ажиллагаатай танилцах;

4. Ажлын хэсгийн санал дүгнэлтийг Байнгын хорооноос гарах шийдвэрийн төслийн хамт боловсруулж Байнгын хорооны хуралдаанд танилцуулах.

-- оОо --



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 02 сарын 07 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.8, 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсгийг тус тус үндэслэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Цөмийн зэвсгээс ангид байх тухай хууль, уг хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 2000 оны 19 дүгээр тогтоол болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих бэлтгэл хангах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Ажлын хэсгийн ахлагч:

Р.Амаржаргал Улсын Их Хурлын гишүүн

Гишүүдэд:

М.Батчимэг Улсын Их Хурлын гишүүн
Н.Энхболд Улсын Их Хурлын гишүүн

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

Ж.Энхсайхан Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд

Ажлын дэд хэсгийн ахлагч:

Ч.Сосорбарам УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны Ажлын албаны ахлах зөвлөх

Гишүүдэд:

Г.Ганболд Гадаад хэргийн яамны Олон талт хамтын ажиллагааны газрын захирал
А.Төмөр Гадаад хэргийн яамны Гэрээ, эрх зүйн газрын захирал
Г.Энхболд Батлан хамгаалах яамны Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын хуулийн зөвлөх
Б.Баярсайхан Тагнуулын ерөнхий газрын ажилтан
Ш.Хишигсүрэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны зөвлөх
Д.Түвшинбилэг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны референт

Д.Ганбат
Д.Мягмар

Стратеги судлалын хүрээлэнгийн захирал
“Цэнхэр сүлд” Төрийн бус байгууллагын гүйцэтгэх
захирал

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Ж.ЭНХБАЯР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 06


Улаанбаатар хот

Тогтоолд нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.8, 21 дүгээр зүйлийн 21.5 дахь заалтыг тус тус үндэслэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос ТОГТООХ нь:

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2015 оны 05 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх дэд хэсгийн бүрэлдэхүүнд Цөмийн энергийн комиссын нарийн бичгийн дарга Г.Манлайжавыг нэмсүгэй.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Ж.ЭНХБАЯР